



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 07 сарын 01 өдөр

Дугаар А/108/4

Номгон


Баянхонгор сумын “Гэгээн сумади” сургууль,
цэцэрлэгийн цогцолборт сургалтын үйл ажиллагаа
эрхлэх тусгай зөвшөөрөл олгох тухай

Боловсролын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1, 23 дугаар зүйлийн 23.1 дэх заалт, 30 дугаар зүйлийн 30.1.6, Аж ахуй үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2.4, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн “Хуулийн этгээд байгуулах тухай” 55, 2021 оны 06 дугаар сарын 21-ны өдрийн “Нэр өөрчлөх тухай” 73 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Боловсрол, соёл урлагийн газрын 2021 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн 188 дугаар албан бичгээр ирүүлсэн дүгнэлтийг хянаж үзэж, Баянхонгор сумын 9 дүгээр багт байрлах 640 хүүхдийн хүчин чадалтай “Гэгээн сумади” сургууль, цэцэрлэгийн цогцолборт сургалтын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн 5 жилийн хугацаагаар олгосугай.

2.Сургууль, цэцэрлэгийн үйл ажиллагааг хууль тогтоомж, стандартад нийцүүлэн явуулж, багшлах боловсон хүчний чадавхыг сайжруулах, боловсролын чанар, хүртээмжийг дээшлүүлэхэд байнга анхаарч ажиллахыг цогцолборын захиралд, сургалтын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, багш ажилтны мэргэжлийн тасралтгүй хөгжлийг хангаж ажиллахыг Боловсрол, соёл урлагийн газар (Ц.Энхтөр)-д, сургуулийн үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Мэргэжлийн хяналтын газар (Н.Бямбадорж)-д үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Б.Наранбаяр)т даалгасугай.



ДАРГА

Д.МӨНХСАЙХАН